

**МОНЛОЖИСТИКС ХОЛДИНГ ХК-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2025 оны 11 сарын 11

№ 25/ТУЗ/47

Улаанбаатар хот

**“ Охин компанид сонирхлын зөрчил бүхий хэлцэл хийх
зөвшөөрөл олгох тухай ”**

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17, 89 дүгээр зүйлийн 89.1, 92 дугаар зүйлийн 92.1 дэх заалт, Монложистикс Холдинг ХК-ийн дүрмийн 7.14.19, Монложистикс Холдинг ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн ээлжит хурлаар Сонирхлын зөрчилгүй бүх гишүүдийн хэлэлцэж шийдвэрлэсэн болон Хараат бус гишүүдийн эчнээ саналыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**


1. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга, хувьцаа эзэмшигч Л. Ганзоригтын эзэмших эрхийн гэрчилгээтэй газрыг нэгдүгээр хавсралтад заасан нөхцөлөөр худалдан авахыг Монложистикс Холдинг ХК-ийн 100%-ийн охин компани болох Монложистикс Экүйпментс ХХК-д зөвшөөрсүгэй.
2. Энэхүү тогтоолыг хэрэгжүүлж, газрын эрх шилжүүлэхтэй холбоотой худалдах, худалдан авах гэрээ байгуулах болон газрыг Монложистикс Экүйпментс ХХК-ийн нэр дээр шилжүүлэхтэй холбоотой газрын алба, холбогдох бусад эрх бүхий байгууллагуудтай гэрээ, хэлцэл хийх болон холбогдох бусад баримт бичигт Монложистикс Экүйпментс ХХК-ийг төлөөлөн гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал /Г. Хишигбат/-д олгосугай.

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА**

Л.ГАНЗОРИГТ



“Монложистикс Холдинг” ХК-ийн Төлөөлөн
Удирдах Зөвлөлийн 2025 оны 11 сарын 11-ний өдрийн
№ 25/ГУЗ/47 тогтоолын Хавсралт №1



Газрын мэдээлэл:

Байршил: Сонгионхайрхан дүүрэг, 20-р хороо, Сонсголон

Газрын хэмжээ: 9,992 м²

Нэгж талбарын дугаар: 1801500812

Гэрчилгээний дугаар: 000520256

Эзэмшигч: Лувсанжамба овогтой Ганзоригт

Худалдах, худалдан авах гэрээний үнийн дүн: 145,083,840 (нэг зуун дөчин таван сая наян гурван мянга найман зуун дөч) төгрөг

Худалдах, худалдан авах гэрээний гол нөхцөл: Газрын дуудлага худалдааны анхны үнэ болох 658,033,152 төгрөгийн 20,04% буюу газрын албанд төлөх төлбөр болон 10%-ийн татвар оролцуулсан дүнгээр худалдана.